

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

03.23 - 03.27



McKinsey агентлагаас 03-р сарын 25-ны өдөр COVID-19-ийн тархалтын эдийн засагт нөлөөлөх судалгаагаар шинэчлэн, эдийн засгийн нөхцөл байдлын боломжит 2 хувилбарыг дэвшүүлсэн байгаа тухай шинжээчийн булангаас хүлээн авна уу.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Мөнгөний бодлогын арга хэмжээнүүд болон урд хожид байгаагүй их хэмжээний эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсонтой холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Мягмар гарагт Dow Jones аж үйлдвэрийн дундаж 1933 оноос хойш хамгийн их нэг өдрийн өсөлт үзүүлсэн бол S&P500 индекс 2008 оны 10-р сараас хойш хамгийн их нэг өдрийн өсөлтийг үзүүлсэн ба АНУ-ын томоохон индексүүд 9%-аас 11%-аар өсжээ.

Газрын тосны үнэ тодорхой хэмжээнд тогтворжиж, АНУ-ын эрх баригчдаас Саудын Арабад ОХУ-тай хийж буй үнийн дайнаа зогсоох талаар шаардлага тавьснаар өмнө нь уналтад орсон байсан эрчим хүчний салбар хамгийн их өсөлттэй байлаа. 60 тэрбум ам.долларын яаралтай тусламжийн хөтөлбөрийг агаарын тээврийн салбарт зарцуулах болсон нь тус салбарт эерэгээр нөлөөлсөн ба үүнийг даган Boeing компанийн хувьцааны ханш өссөнөөр үйлдвэрлэлийн салбар өсөлттэй байлаа. Мөн ус, цахилгаан, дулааны салбар өсөлттэй байсан бол харилцаа холбооны салбар уналттай байлаа.

Европ: Европын улсууд болон АНУ түүхэнд байгаагүй их дүнтэй эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр болсонтой холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдсан байна. STOXX Europe 600 индекс, ХБНГУ-ын DAX индекс, Франц улсын CAC 40 индекс болон Итали улсын FTSE MIB индексүүд бүгд 5%-аас 8%-аар өссөн байна. Английн фунтийн ханш сул байгаа нь экспортод дэмжлэг үзүүлж, Их Британийн FTSE 100 индекс өсөхөд нөлөөлсөн байна.

Их Британийн гадаад худалдааны томоохон хамтрагч улсуудын мөнгөн тэмдэгтийн эсрэг фунтын ханш суларч түүхэн доод цэгтээ хүрээд байна. Английн Төв Банк бодлогын хүүгээ 0.1% хэвээр хадгалаад байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд 645 тэрбум фунтийн бонд худалдаж авах хөтөлбөрийн дүн нэмэгдүүлнэ хэмээн мэдэгдсэн байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Nikkei 225 индекс 17.1%-аар буюу 2,837 нэгжээр өсөж 19,389.43 хүрсэн хэдий ч өмнөх оны мөн үеэс 18%-аар бага байгаа юм.

Nikkei агентлагаас, хэдийгээр 2020 оны төсөв батлагдсан хэдий ч Ерөнхий сайд Шинзо Абэ болон түүний засгийн газар нийт 56 их наяд иен буюу 500 тэрбум ам.долларын эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг батлуулахаар ажиллаж байгаа гэж мэдээлжээ. Энэхүү хөтөлбөр нь Японы ДНБ-ний 10%-тай тэнцүү байгаа бөгөөд батлагдсан тохиолдолд, тус улсын түүхэн дэх хамгийн их хэмжээний эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөр болох юм.

БНХАУ: БНХАУ-ын томоохон индексүүд долоо хоногийн эхэн үеэр өсөлттэй байсан ч долоо хоногийн сүүлээр бууралт үзүүлж, энэ долоо хоногт Shanghai Composite индекс 4.2%-аар, CSI 300 индекс 5.2%-аар өссөн үзүүлэлттэй хаагдлаа.

Одоогийн байдлаар БНХАУ-ын эрх баригчид ямар нэгэн хөтөлбөр хэрэгжүүлэх тухай мэдэгдэл хийгээгүй байгаа хэдий ч шинжээчид эдийн засгийг дэмжих ямар нэг хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж таамаглаж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,160.90	-5.48% ▼
Dow Jones	АНУ	21,636.78	12.84% ▲
S&P 500	АНУ	2,541.47	10.26% ▲
Nasdaq	АНУ	7,502.38	9.05% ▲
S&P/TSX	Канад	12,687.74	7.05% ▲
FTSE 100	Их Британи	5,510.33	6.16% ▲
S&P/ASX 200	Австрали	4,842.40	0.54% ▲
Nikkei 225	Япон	19,389.43	17.14% ▲
Hang Seng	Хонг Конг	23,484.28	8.18% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	94.27
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	89.53
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	89.56
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	98.91
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.39
DBM' 2023	USD	7.250%	85.86
TDBM' 2020	USD	9.375%	97.06
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	90.31

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.989	0.06 ▲
Libor 3M	1.450	0.25 ▲
Libor 6M	1.072	0.08 ▲
Libor 1YR	0.969	0.04 ▲
US 2YR Bond	0.238	-0.06 ▼
US 3YR Bond	0.285	-0.04 ▼
US 5YR Bond	0.378	-0.04 ▼
US 10YR Bond	0.650	-0.16 ▼

Валютын ханш	2020.03.27	Өөрчлөлт
USD	2,775.43	0.17% ▲
CNY	391.56	-0.29% ▼
EUR	3,061.02	2.15% ▲
RUB	35.69	0.48% ▲
KRW	2.28	1.79% ▲
JPY	25.51	0.83% ▲
CAD	1,976.52	1.45% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,628.16	8.64% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	14.47	14.67% ▲
Зэс	USD/lb.	217.20	0.02% ▲
Нүүрс	USD/MT	70.68	5.76% ▲
WTI газрын тос	USD/bbl.	21.51	-4.10% ▼
Brent газрын тос	USD/bbl.	24.93	-7.60% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. II	6.4%
Бодлогын хүү	2020. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. II	10.95 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. II	11.33%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. II	4.71%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. II	17.01%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. II	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 1,437.5 сая төгрөгийн 4,674,014 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хар Хорум Пропертийс” /АМТ/ компанийн хувьцаа 31.37%-аар буюу хамгийн ихээр өсөж 185.80 төгрөг хүрч хаагдсан бол “Ремикон” /RMC/ компанийн хувьцаа 21.16%-аар буурч 21.27 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

03-р сарын 27-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,482.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 17,160.90 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 5.48%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	1,437.5	
Зах зээлийн үнэлгээ	2,482,643.1	
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,160.90	-5.48% ▼
MSE I индекс	7,922.20	-10.26% ▼
MSE II индекс	7,621.13	-0.66% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Фронттиер лэнд групп	2,097,323	629,268,760
Монгол шуудан	555,945	339,821,463
АПУ	132,066	79,353,958
Ард санхүүгийн нэгдэл	112,825	67,363,561
Инвескор ББСБ	2,582	52,938,789
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хар хорум пропертийс	185.80	31.37% ▲
Дархан гурил тэжээл	5,700.00	16.83% ▲
Хэрлэн хивс	41.40	15.00% ▲
Гутал	20,400.00	13.27% ▲
Лэндмн ББСБ	30.96	8.78% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Ремикон	21.27	-21.16% ▼
Жуулчин дюти фри	65,050.00	-20.67% ▼
АПУ	513.31	-17.52% ▼
Мерекс	15.00	-16.67% ▼
Монгол алт	5,550.00	-14.62% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)	
Ард Секюритиз	865,564,618	
Бидисек	755,214,033	
Евразиа Капитал Монголиа	628,779,550	
Стандарт Инвестмент	104,101,812	
Масдак	96,731,127	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	513.31	662,261
Таван толгой	6,300.00	342,324
МИК Холдинг	11,910.00	287,652
Инвескор ББСБ	2,500.00	186,493
Говь	180.54	161,951

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	NA	2020.05.01-ЭЭС

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ээлжит VI хуралдааныг цахимаар зохион байгуулж даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоотой холбоотой тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, оноосон нэр өөрчлөх, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Фронттиер лэнд групп” ХК: “БиДиСек” ХК-аас хувьцаагаа эргүүлэн худалдан авлаа.

“БиДиСек” /MSE:BDS/ ХК өөрийн эзэмшиж байсан “Фронттиер лэнд групп” /MSE:MDR/ ХК-ийн хувьцаагаа худалдахаар, “Фронттиер лэнд групп” /MSE:MDR/ ХК-д санал өнгөрөгч онд тавьж байсан ба компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2019 оны 10 сард өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөө худалдан, хувьцаагаа эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн байсан ба тус хэлцэл 2020 оны 03-р сарын 26-ны Пүрэв гарагийн арилжаагаар хийгджээ.

Тус өдрийн арилжаагаар “Фронттиер лэнд групп” /MSE:MDR/ ХК-ийн 2,097,323 ширхэг хувьцаа 629.3 сая төгрөгөөр арилжигдсан байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Хар хорум пропертис” ХК: нэгж хувьцаагаа 10 хуваана.

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй “Хар хорум пропертис” /MSE:AMT/ ХК, хувьцаагаа 10 хуваахаар төлөвлөж байна.

Ингэснээр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15.79 сая ширхэг хувьцаатай байсан бол 10 төгрөгийн үнэтэй 157.87 сая ширхэг хувьцаатай болох юм.

Компанийн хуулийн дагуу, хувьцаа хуваах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх ёстой байдаг ба компаниас 04-р сарын 29-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлаад байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Адуунчулуун” ХК: 2020 онд алдагдлаа бууруулна.

“Адуунчулуун” /MSE:ADL/ ХК 2019 онд 585 мянган тонн нүүрс олборлож, зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй ажилласан ч 54%-ийн гүйцэтгэлтэй буюу 315.4 мянган тонн нүүрс олборлосон байна.

Компани нь нүүрсний гол худалдан авагч болох “ДБЭХС” ТӨХК-аас шууд хамааралтай байдаг бөгөөд олон жил дангаараа дотоодын зүүн бүсийн зах зээлд эрчим хүчний нүүрс борлуулж байсан бол “Монголын алт” ХХК нь Адуунчулууний орд дахь “Дорнод МАК” нүүрсний уурхайгаас олборлолт хийж эхэлсэн нь компанид шинэ сорилт болж байна.

Иймд компанийн удирдлагын зүгээс энэ онд станцад нийлүүлж байгаа нүүрсний үнийг нэмэгдүүлэхийг зорьж, Эрчим хүчний зохицуулах хороотой хамтран ажиллан гэдгээ мэдэгдлээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

БУСАД МЭДЭЭ



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02-р сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор баталсан “Арилжааны журам”-ын нэмэлт өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2020 оны 03-р сарын 19-ны 123 тоот тушаалаар батламжилсан байна.

Уг нэмэлт өөрчлөлтөөр МХБ-ийн арилжааны хэлцэл баталгаажуулах, хэлцэл цуцлах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаснаас гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, сангийн нэгж эрх зэргийг арилжих, тэдгээрийн арилжааны шимтгэл хураамжийн талаар нэмж орууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

“COVID-19” цар тахал газар авч буй энэ үед Монгол Улсын эмнэлгийн тусламж үйлчилгээг бэхжүүлэхэд туслах зорилгоор Дэлхийн банкнаас 2.2 сая ам.долларын санхүүжилт олгохоор боллоо.

Тус санхүүжилтийг улсын хэмжээнд нэн шаардлагатай байгаа эмнэлгийн оношилгооны тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулна. Тухайлбал: 15 суурин ба 12 зөөврийн дижитал рентген аппарат, 41 хэт авианы оношилгооны аппарат зэрэг тоног төхөөрөмж худалдан авах юм. Тоног төхөөрөмж дөрөвдүгээр сарын эхээр Монголд тээвэрлэгдэн ирэх төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын Засгийн газар цар тахлын үед эдийн засгаа дэмжихээр нийт 5.1 их наяд төгрөгийн багц санхүүжилт хийх болсноо мэдэгдлээ. Үүний дотор одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд 159 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт хийх болж байна.

Бизнес, компаниудад дэмжлэг болгож, 04-р сарын 01-ээс 10-р сарын 01-ний өдөр хүртэл аж ахуйн нэгжүүдийн Нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн тэглэхээр боллоо. 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдээс орлогын албан татвар авахгүй, хувь хүний орлогын албан татварыг тэглэнэ гэсэн шийдвэрүүд энэхүү багцад багтжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхнээс 03-р сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд чулуун нүүрсний экспорт 55%-аар буурч, 2.9 сая тонн болсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ.

Гашуунсухайт боомтоор 1.47 сая тонн чулуун нүүрс гаргасан нь жилийн өмнөхөөс 53.6%-аар буурсан бол Шивээхүрэн боомтын экспорт 74.4%-аар буурч, 718.5 мянган тонн чулуун нүүрс гаргасан байна. Ховдын Булган боомтоор 128.7 мянган тонн чулуун нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 41.1%-аар буурсан талаар Гаалийн ерөнхий газар мэдээлэв.

Мөн хугацаанд зэсийн баяжмалын экспорт 13.6%-аар буурч, 283.9 мянган тонн болсон талаар Гаалийн ерөнхий газар мөн мэдээллээ. Гашуунсухайт боомтоор гаргаж байгаа “Оюу Толгой”-ийн зэсийн баяжмалын экспорт оны эхнээс 03-р сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд 24.8%-аар буурч, 139.5 мянган тонн болсон байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МCKINSEY АГЕНЛТАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТААМГИЙН ХУРААНГУЙ

Өнгөрөгч долоо хоногт гарсан халдварын болон эдийн засгийн үзүүлэлтүүдэд үндэслэн McKinsey агентлаг 03-р сарын 25-ны өдөр COVID-19 тархалт болон түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийн таамаглалаа хялбаршуулан 2 боломж дэвшүүлсэн байна.

Гэхдээ улс орнуудад тархалтын тоо их хэмжээгээр нэмэгдэж байгаа ба мэргэжилтнүүд тархалтыг зэрэгт хэлбэрээр нэмэгдэнэ хэмээн таамаглаж байгаа юм. Хамгийн муу тохиолдолд, улс орнуудын хариу арга хэмжээ хангалтгүй байж, улсууд эдийн засгийн болон нийгмийн их хэмжээний хохирол амсах боломж байсаар байгаа юм. McKinsey агентлагаас нийтэлсэн вирусийн тархалт, тус үеийн эдийн засгийн таамаглалыг доор тусгасан байгаа ба энэхүү таамаглалууд нь олон боломжит хувилбарын нэг гэдгийг анхаарна уу.

Удаашралтай сэргэлт

Тархалтын хувьд: Энэхүү нөхцөлд, вирусийн тархалт Америк болон Европ тивд 4-р сарын дунд үе хүртэл өсөх ба Азид тархалт намжиж Африк тив болон далайн улсуудад тархалт бага хэмжээтэй байна.

Улсын болон засаг захиргааны нэгжийн хэмжээний хөл хорио тогтоох, ажил олгогчид гэрээс ажиллах боломж үүсгэх болон иргэд хувийн ариун цэврийг сайтар сахих зэрэг арга хэмжээнүүдээс үүдэн тархалтын хурд удааширна. Энэ эрүүл мэндийн системд вирусийн шинжилгээг үр дүнтэй авах хугацааг олгох ба вирусийн тархалт улирлын шинж чанартай бол энэ нь тархалтыг цааш улам сааруулах боломжтой юм. Дэлхийн өмнөд хэсгээр өвөл болохтой холбоотой тархалтын хэмжээ ихсэх ба 2020 оны намрын улиралд тархалт дахин сэрэх боломжтой ч тэр үед улс орнууд авах хариу арга хэмжээнүүдийг бэлдсэн байх ба эдийн засгийн нөлөө харьцангуй бага байх юм.

Эдийн засгийн хувьд: Нийтийг хамарсан хөл хорио, аялалын хязгаарлалт болон тусгаарлалтын арга хэмжээнүүдээс үүдэн хувийн хэрэглээ болон бизнесийн үйл ажиллагаа 2-р улирлыг дуустал бууран, эдийн засаг уналтад орох юм. 2-р улирлын сүүл гэхэд дэлхийн ихэнх улсууд тархалтыг амжилттай хязгаарлаж чадах ч эдийн засгийн уналтын өөрийгөө бэхжүүлэх динамик чанараас үүдэн 3-р улирлын сүүл хүртэл эдийн засгийн уналт үргэлжлэх юм. Хэрэглэгчид хэрэглээгээ

бууруулан, бизнесүүд орлогогүй болж ажилтнуудаа цомхтгож, ажилгүйдлийн хэмжээ огцом нэмэгдэнэ. Компаниуд дампуурах аюулд орж, бизнес эрхлэгчид эх үүсвэр хайж эхэлснээр санхүүгийн систем ачаалалд орно.

1-р улиралд мөнгөний бодлогыг зөөлрүүлсэн ч хүүгийн түвшин аль хэдийн бага байгаатай холбоотой нөлөө бага байна. 2 болон 3-р улиралд хэрэгжих эдийн засгийг дэмжих хөтөлбөр хохирлыг даван гарахад хангалтгүй байх юм. АНУ болон Европын эдийн засаг 4-р улирал хүртэл сэргэхгүй ба 2020 онд дэлхийн эдийн засаг бууралттай байна.

Уналт үргэлжлэх

Тархалтын хувьд: Энэхүү тохиолдолд, вирусийн тархалт Америк болон Европ тивд 5 сарыг дуустал өсөлттэй байх ба засгийн газрын арга хэмжээнүүдийн үр нөлөө сул байх холбоотой эрүүл мэндийн систем ачаалалд орно. Мөн вирус нь улирлын чанаргүй бол жилийн сүүл үе хүртэл шинэ халдварын тохиолдлууд гарсаар байна. Африк тив, далайн улсууд болон зарим Азийн улсуудад тархалт хүчтэй явагдах ба хүн амын насжилт багатай улсууд л хохирол багатай гарна. Тархалтыг хязгаарлаж чадсан улсууд дахин дэгдэлт үүсгэхгүй тулд нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авсан хэвээр байх болно.

Эдийн засгийн хувьд: Хэрэглэгчид хэрэглээгээ бууруулахын хэрээр жилийн эрэлтийн түвшин их хэмжээгээр цохилт амсана. Вирусийн тархалтад хамгийн эмзэг байгаа салбарууд их хэмжээгээр ажилтнуудаа цомхтгох эсвэл дампуурах эрсдэлд орж эдийн засгийн уналт хүндэрнэ.

Санхүүгийн систем их хэмжээний дарамтад орох ч банкуудын капиталжуулалт болон нэмэгдүүлсэн хяналтын тогтолцооноос үүдэн санхүүгийн хямрал нүүрлэхгүй. Сангийн болон Мөнгөний бодлогын шийдвэрүүд эдийн засгийн уналтыг сэргээхэд хангалтгүй байна.

Дэлхийн эдийн засаг 2008 болон 2009 оны хямралтай ижил эсвэл илүү хэмжээний уналтад орно. 2020 онд ихэнх томоохон эдийн засгуудад хямралд нүүрлэх ба 2021 оны 1-р улирлаас сэргэлт ихэснэ.

Эх сурвалж: McKinsey & Company

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.